МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Зөв зүгт
манлайлна

2021 ENTREPRENEUR
САЙН ЗАСАГЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ЭНТРЕПРЕНЁР

MNCA.MN

2025.10

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.БАТСҮХ:

МБҮА ТББ-ЫН УДИРДЛАГУУД БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТӨСӨЛД ҮНДЭСНИЙ КОМПАНИУДАА ОРУУЛЖ ЧАДСАН

Б.САРАНЧИМЭГ:

НҮБ-ААС МОНГОЛ УЛСЫН БАРИЛГА, ОРОН СУУЦНЫ ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД

МЕГА ТӨСЛҮҮДИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ИРГЭД, ОЛОН НИЙТ, АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ИЛ ТОД БАЙЛГАХ ХЭРЭГТЭЙ



INTERNATIONAL FEDERATION OF ASIAN AND WESTERN PACIFIC CONTRACTORS' ASSOCIATIONS

INTERNATIONAL FEDERATION OF CONSULTING ENGINEERS

МБҮА

+976-7011 1515

info@mnca.mn

www.mnca.mn

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци

РЕДАКЦИ

ХЯНАН ТОХИОСОН:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.БАТСҮХ

НЭГТЭЛ РЕДАКТОР:
Б.ТӨВШИНБОЛОР

ОРОЛЦСОН:
АЖЛЫН АЛБА

АГУУЛГА

НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД:

- ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ, САЛБАРЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, НОРМ, ДҮРЭМ ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР
- ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР
- ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГАА ӨРГӨЖҮҮЛЭХ

НИЙГМИЙН ҮНЭ ЦЭНИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД:

- ХОТ СУУРИН ГАЗАР, ДАГУУЛ ХОТУУДЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД
- ДЭД БҮТЭЦ, ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД

ГИШҮҮНЧЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД:

- УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
- ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДЫН ТОО, ГРАФИК, ҮЗҮҮЛЭЛТ
- ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДАА САЛБАРЫН БОДЛОГО, СУДАЛГААГААР ХАНГАЖ АЖИЛЛАЖ БАЙГАА БАЙДАЛ
- ГИШҮҮДИЙГ СУРГАЛТ, ТУРШЛАГА СУДЛУУЛАХ АЯЛАЛ, ВОРКШОП АРГА ХЭМЖЭЭНД ХАМРУУЛСАН БАЙДАЛ
- ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОЛОН НИЙТ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛЭЭР СУРТАЛЧИЛСАН НЬ

МБҮА

SINCE 2009

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

Зөв зүгт Манлайлна



МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Зөв зүгт Манлайлна

21 АЙМАГТ АССОЦИАЦИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙГ байгуулж эхэллээ

АССОЦИАЦИ НЬ САЛБАР ЗӨВЛӨЛҮҮДТЭЙ ДАРААХ ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАНА.

- Сургалт, зөвлөгөөн
- Туршлага солилцоо
- Төслүүд, хөрөнгө оруулалт
- Шударга өрсөлдөөн, стандартын хяналт

7011 1515 info@mnca.mn
www.mnca.mn



БАЯН-ӨЛГИЙ **ХОВД** **ДАРХАН-УУЛ**

Аймгуудад САЛБАР ЗӨВЛӨЛ-ийг байгуулаад байна.

I.Нөлөөллийн үйл ажиллагааны зорилтын хүрээнд




www.mnca.mn


МЕГА ТӨСЛҮҮДИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ИРГЭД, ОЛОН НИЙТ, АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ИЛ ТОД БАЙЛГАХ ХЭРЭГТЭЙ

Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэгдэж буй яг энэ цаг үед Монголын Нээлттэй нийгэм хүрээлэнгээс Засгийн газрын болон Нийслэлийн мега төслүүдэд хийсэн ил тод байдлын судалгааны талаар 2025.10.09-ний өдөр зохион байгуулж уулзалтад Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, УИХ-ын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтэс, Үндэсний Аудитын газар, Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс, Сангийн яам, Нийслэлийн МАН-ын хороо, 20 минутын хот хөгжлийн төв, МБҮА ТББ болон иргэний нийгмийн төлөөллүүд оролцлоо.

Судалгаагаар Засгийн газрын 14 мега төслөөс 6 нь, нийслэлийн 14 мега төслөөс дөрөв нь хэрэгжиж эхэлсэн ба хэрэгжилтийн бэлтгэл хийгдэж буй Засгийн газрын 4, нийслэлийн таван төсөл, судалгаа, төлөвлөлтийн шатанд Засгийн газрын 4, нийслэлийн 14 мега төсөл буюу **Дараах:**



-Гашуунсухайт-Ганцмодны боомтын хил дамнасан төмөр зам
-Газрын тос боловсруулах үйлдвэр
-Ураны төсөл
-Зэс боловсруулах цогцолбор
-Гангийн цогцолбор
-Эрдэнэбүрэнгийн 90 мат-ын усан цахилгаан станц
-Баянхошуу хот орон сууцжуулах төсөл
-Сэлбэ хот" орон сууцжуулах төсөл
-Эмээлт" эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтэц
-Дүүжин замын тээвэр



-Багахангай-Хүннү хот чиглэлийн салбар төмөр замын төслүүд тодорхой хэмжээгээр хөдлөөд эхэлсэн тухай дурдлаа.

Гол нь Засгийн газрын болон нийслэлээс хэрэгжүүлж буй нэг нэг төслүүд жил бүрийн тайлангаа ил тод, нээлттэй байршуулсан бол бусад төслүүдийн тухайд ямар нэгэн веб сайт, мэдээлэл авч болохуйц эх сурвалж байхгүй байгааг дурдсан юм.

Мега төслүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явц өөрөө тодорхой, хууль эрх зүйн суурьтай буюу Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлоготой уялдах ёстой байтал одоогоор Монгол Улсыг 2025-2031 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн баримт бичиг гэдэг зүйл байхгүй байгааг онцолсон юм. Гол нь олон талын оролцоотой, том төсөвтэй, эдийн засагт нөлөөтэй Мега төслүүд хэрэгжүүлж байгаа бол үүнийг төлөвлөх, хуваарилах, эрэмбэлэх зэрэг бүх үе шатууд нээлттэй, хариуцлагатай байх ёстой байтал дээрх хэрэгжүүлж байгаа төслүүд нь мөрөөдлийн жагсаалт маягийн зүйл болоод байгааг судалгаагаар гаргаж ирсэнээ дурдсан юм.

Харин АТГ-ын зүгээс уг судалгааг хийхдээ олон нийтэд алийг нь ил тод нээлттэй байлгах тал дээр ойлгомжтой болгох тал дээр нь санал санаачилга гаргаж хийхгүй бол улс орны хэмжээний үндэсний аюулгүй байдалд ч нөлөөлөхүйц хэмжээний том Мега төслүүдийн талаарх мэдээллийг нэг бүрчлэн ил тод байлгахад хүндрэлтэй байдаг талаар дурдсан юм. Монгол Улсын УИХ-ын чуулганаар 2026 оны төсвийн хүрээний мэдэгдлийг хийж томоохон Мега төслүүдийг үргэлжүүлэх, дуусгахад ямар хэмжээний хөрөнгө мөнгө төвлөрүүлж, хаанаас ямар санхүүжилтийн эх үүсвэрээр уг төслүүдийг хэрэгжүүлэх нь тодорхойгүй төслүүдийг эрэмбэлэх зэрэгт энэхүү судалгааны тайлан үр дүнгээ өгнө гэдэгт судлаачид илтгэлтэй байгаа талаар дурдсан юм.



МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн ээлжит III хурал нь 2024.10.25-ны өдөр болж МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирлаар Г.Батсүхийг томилсон бөгөөд **ӨНГӨРСӨН НЭГ ЖИЛИЙН ХУГАЦААНД:**

- ФОРУМ, АРГА ХЭМЖЭЭ
- ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ-ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД
- МЕГА ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД
- ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨГЖҮҮЛЭЛТ, СУРГАЛТ
- ОРОН НУТАГТ САЛБАР ЗӨВЛӨЛТЭЙ БОЛСОН ТУХАЙ
- “ДУЛААН ШИЙДЭЛ2” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД
- ТУЛГАМДСАН АСУУДЛУУДЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД-аар талаарх тайланг нийт гишүүн байгууллагууд болоод олон нийтэд хүргэн ажиллалаа.

ОЛОН УЛСАД НЭР ХҮНД БҮХИЙ ОХУ-ЫН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН “BASALT TECHNOLOGIES” СЭТГҮҮЛД МОНГОЛ КОМПАНИЙН ТАЛААР АНХ УДАА НИЙТЛЭГДЛЭЭ


www.basalt-online.ru
Январь-декабрь 2019-2021
Научно-технический отраслевой журнал
БАЗАЛЬТОВЫЕ ТЕХНОЛОГИИ
91

НОВОСТИ ЗАРУБЕЖНЫХ КОМПАНИЙ

«БАЗАЛЬТОВЫЙ ЧЕЛОВЕК» В МОНГОЛИИ

Ганбаатар Дававадорж
Редактор журнала BUSINESS.MN, Монголия

В начале 1990-х годов многие монгольские инженеры, ученые, бывшие государственные деятели и простые люди, потерявшие работу, занялись так называемой челночной торговлей, чтобы выжить в новой реальности. Большинство крупных сегодня бизнесменов начали свой путь именно с этого. Но Лхагважавын Ариунболд пошел другим путем. Когда все вокруг оставили свои заводы и ринулись за границу с клетчатыми сумками, он долгое время сидел в Патентном бюро, чтобы изучать советские технологии производства стекол для транспортных средств.

Так как в то время в связи с прекращением поставок стекол из СССР оно было одним из самых востребованных материалов для монгольских потребителей, его идея успешно воплотилась в жизнь. Он поставлял свою продукцию владельцам автомобилей, автобусному парку и троллейбусному депо, даже УБЖД. «Существовала довольно забавная практика, когда автомобили успешно прошли техосмотр несмотря на то, что лобовые стекла отсутствовали наполовину, а наполовину были переклеены скотчем», – вспоминает Л. Ариунболд.

Он закончил Уральский политехнический институт (УРФУ), где учился на «силикатчика»

К концу 1990-х годов, с появлением в Монголии дилеров зарубежных автопроизводителей, бизнес по производству лобовых стекол стал неперспективным. Но Л. Ариунболд заработал достаточно средств по тогдашним меркам. Он много путешествовал и посещал разные промышленные выставки.

После принятия Киотского протокола в развитых странах стала актуальна тема о важности энергосберегающих теплоизоляционных материалов. В это же время в Монголии стремительно вырослo производство стекловаты и пенополистирола различного типа. Но Л. Ариунболд не испытывал симпатии к этим материалам, хотя была возможность зарабатывать на них много денег. Он любил каменную вату потому, что был твердо уверен в том, что это материал будущего. К тому же он имел опыт работы на заводе каменной ваты в Челябинске, когда он был еще студентом УПИ (УрФУ).

Однажды он познакомился с одним датским инженером на международной выставке «Global Insulation Conference & Exhibition». Этот человек ему подробно рассказал о перспективе производства каменной ваты в Монголии, но предупредил, что успешная реализация такого проекта будет трудной, пока власть Монголии не осознает важность этого материала, чего Л. Ариунболд тогда не очень понимал.

Речь датского инженера была настолько убедительна, что по возвращении в Монголию Л. Ариунболд сразу же начал исследования по созданию завода каменной ваты. Он ездил в Россию и в Китай, чтобы узнать, как у них обстоят дела с каменной ватой.

Прошло пять лет поисково-исследовательских работ, на которые ушла большая часть средств, накопленных благодаря производству лобовых


92
БАЗАЛЬТОВЫЕ ТЕХНОЛОГИИ
www.basalt-online.ru
Январь-декабрь 2019-2021

НОВОСТИ ЗАРУБЕЖНЫХ КОМПАНИЙ

стекол. Нашли хорошее месторождение в Багануре, вблизи Улан-Батора. Из Японии прислали результаты проб монгольских базальтов, где было сказано, что модуль кислотности оказался выше среднего. Это означало, что продукция будет высококачественной, но требует расплава в более высокой температуре и больших затрат на производство.

Чтобы открыть завод, Л. Ариунболд собрал своего рода «мозговую» – чертежи из России, оборудование из Китая и Японии. После семи лет упорного труда с момента встречи с датским инженером он получил первый рулон каменной ваты, произведенный на его заводе, хотя температура расплава не достигла необходимого уровня. Таким образом была заложена основа национального производства базальтовой ваты в Монголии. В 2006 году он создал предприятие «МОНГОЛ БАЗАЛЬТ».

К сожалению, как сказал датский инженер, тогда в Монголии люди не имели представления о том, что такое базальт. Поэтому Л. Ариунболду пришлось поставляться, чтобы найти необходимые денежные средства. К счастью, появились крупные проекты, которые были нужны частные теплоизоляционные материалы. Первым проектом, заказы которого он выполнил, стала конная статуя Чингисхана недалеко от столицы – крупнейшая конная статуя в мире.

За этим следовали большие строительные проекты, такие как Холидей Инн, Шангри Ла и многие другие объекты национальных строителей. Сегодня многие государственные и частные предприятия покупают продукцию «МОНГОЛ БАЗАЛЬТ» без объявления тендера, так как он является единственным национальным производителем в Монголии.

Л. Ариунболду потребовалось пятнадцать лет, чтобы внедрить в жизнь экономически-чистую продукцию, конкурентоспособную на региональном рынке. Он этим очень гордится.

Очень большая проблема в Монголии – это теплопотери в различных объектах гражданского и промышленного назначения в окружающую среду. К примеру, жилые дома, построенные в советские времена, сегодня очень нуждаются в перетеплении. Кроме этого, для минеральной ваты важным направлением является энергетическая отрасль Монголии, которой нужна основательная модернизация. Именно, в этом и заключается социально-экономическое значение предпринимательской деятельности Л. Ариунболда.

Инновационный пакет для регионального рынка

Долгие годы Л. Ариунболд «собирал кусочками» свой завод и расширял его. В последние годы он сотрудничает с компанией Gamma Meccanica S.p.A. из Италии. Но «МОНГОЛ БАЗАЛЬТ» можно назвать инновационным потому, что часто монгольского характера. С точки зрения технологии и рынка, это далеко. «МОНГОЛ БАЗАЛЬТ» немало преимущества. Они открыли возможность «МОНГОЛ БАЗАЛЬТ» экспортировать свою продукцию. Но налоги экспорта у Л. Ариунболда есть свои понятия, которые отличаются от распространенного мнения о том, что экспортировать из Монголии невыгодно. Он собирается открывать совместные предприятия в регионах близко к монгольской границе. «Сегодня мы можем экспортировать продукцию не через границу, а через фабрику, поставляя свои знания, технологии, ноу-хау и опыт», – подчеркивает Л. Ариунболд. Он уже заключил договор с российскими

Январь-декабрь 2019-2021
БАЗАЛЬТОВЫЕ ТЕХНОЛОГИИ
93

НОВОСТИ ЗАРУБЕЖНЫХ КОМПАНИЙ

предпринимателями по созданию совместного предприятия по производству минеральной ваты в Иркутской области. Подобные предложения поступают из Кыргызстана и Узбекистана. Но ключевую, что такой завод понадобится во Внутренней Монголии, потому что они постепенно отказываются от шлаковой ваты.

Наследие

Сегодня Лхагважавын Ариунболд – известный предприниматель в Монголии и основатель акционерного общества «МОНГОЛ БАЗАЛЬТ». Он лучший инженер-конструктор, заслуженный работник промышленности Монголии и инвестор. Л. Ариунболд имеет три патента, защищенных в Монголии (BASALTWOOL®; BAZALIT®; TERMOBASALTE), три полезные модели, одно свидетельство об авторском праве и один патент, находящийся под международной охраной ин-теллектуальной собственности (BASALTWOOL). А еще он со школьных лет занимается любительским спортом – баскетболом, хоккеем, плаванием – и даже стал мастером спорта по хоккею с шайбой. Сейчас работает вице-президентом федерации хоккея Монголии.

Большая часть его жизни связана с родным Уральским федеральным университетом. Развитие технологии изготовления каменной ваты в Монголии во многом обязано плодотворному сотрудничеству с этим вузом. Эффективность производства каменной ваты на предприятии «МОНГОЛ БАЗАЛЬТ» существенно повышена именно за счет такой совместной работы. В 2020 году в этом университете Л. Ариунболд защитил докторскую диссертацию.

Кроме предпринимательства, он, как инвестор активно инвестирует в образование будущих инженеров-конструкторов. В 2011 году Л. Ариунболд создал учебно-конструкторский центр «Юнкмат», где дети в возрасте с 6 до 12 лет занимаются на современном оборудовании.

«Деньги меня не волнуют. Они всегда находятся, когда ты делаешь хорошее дело. Самое важное – оставить хорошие истории», – заключает он.

Л. Ариунболд с С.В. Отрешковым на церемонии умения их совершенного первого для Международной научно-практической конференции «Базальтовые технологии в России – 2016» г. в Борисовском государственном национальном исследовательском университете, 29 мая 2016 г.

2.НИЙГМИЙН ҮНЭ ЦЭНИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД



САЛБАРЫН БОДЛОГО СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

- Барилгын ерөнхий хууль, Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төслүүдийн шинэчлэгдсэн ажлын хэсэгт орж, 3 удаагийн хуралд оролцож, хуулийн үзэл баримтлалын төсөлд саналаа хүргүүлж ажиллалаа.
- ХББОСЯ-наас жил бүр Барилгын салбарын шилдэг 10 компани шалгаруулах шалгуур үзүүлэлтийг шинэчлэн, санал боловсруулан ГЗ-д танилцуулахаар өгсөн болно.
- МҮХАҮТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг нийт гишүүдэд хүргүүлж, гишүүдээс ирүүлсэн саналыг нэгтгэн хүргүүлж ажиллалаа.

Үр дүн: МБҮА ТББ нь гишүүдийнхээ дуу хоолой болж хууль, төрийн бодлого, шийдвэрт санал бодлыг нь хүргэх чиг үүргээ хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулаа.

- Барилгын компаниудын чадавхыг үнэлэх, эрэмбэлэх судалгааны чиглэлээр SICA ХХК-тай хамтран ажиллах гэрээний төслийг бэлтгэн хүргүүлж саналыг авах, уулзалт зохион байгуулахаар ажиллаж байна.
- Мэргэжлийн Нэгдсэн Холбоо байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн ажил МБҮА ТББ-ын АА-ны үйл ажиллагаанаас үл хамааран түр зогссон ч ажлын хэсгийн ажил үргэлжлэх үед дэмжин ажиллаж гишүүдийн саналыг авч нэгтгэх, танилцуулна.

Үр дүн: Мэргэжлийн Нэгдсэн Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн болон бусад байгууллагуудтай хамтарч ажиллах санамж бичгийн хэрэгжилтийг хангахад чухал ажил болсон.

Гишүүнчлэл, хамтын ажиллагаа, гадаад харилцааны чиглэлээр:
МБҮА ТББ-ын орон нутаг дахь салбар, зөвлөл байгуулах, өргөтгөх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Дархан-Уул аймгийн салбар зөвлөлийн тэргүүнтэй Ажлын албаны СБТСХ-ийн дарга уулзалт хийж, 11 дүгээр сард сургалт зохион байгуулах болон 2026 онд хэрэгжүүлэх ажлын чиглэлийн талаар ярилцаж санал солилцлоо.
Үр дүн: Орон нутгийн салбар, зөвлөл болон тэдгээрийн гишүүдийн хамтын ажиллагаанд шинэ алхамыг бий болгоход чухал хувь нэмэр оруулаа.

“НЭЭЛТТЭЙ ПАРЛАМЕНТ: ЭКСПЕРТ-2025” ХӨТӨЛБӨРТ МБҮА ТББ-ЫН МЕНЕЖЕР Б. САРАНЧИМЭГ АЖИЛЛАЖ БАЙНА




УИХ-аас санаачилсан “Нээлттэй парламент: Эксперт”- 2025 хөтөлбөрийн хүрээнд эдийн засаг, геофизик, санхүү, математик, геологи, хууль, статистик, сэтгэл судлалын чиглэлээр 30-аас дээш ажилласан туршлагатай 13 ахмадыг сонгож, хууль тогтоох, төрийн бодлого тодорхойлох, хяналт шалгалт хийх үйл ажиллагааг олон нийтэд таниулах, шийдвэр гаргах түвшинд ахмадын оролцоог нэмэгдүүлэх, харьцуулсан судалгаа хийх, бодлого боловсруулах, зөвлөх чиглэлээр ажиллуулж байгаа бөгөөд уг хөтөлбөрт МБҮА ТББ-ын Салбарын бодлого, төлөвлөлт, судалгааны хэлтсийн менежер Б.Саранчимэг хамрагдан ажиллаж байна.
Уг хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэж байгаатай холбогдуулан төсвийн эрэмбэ тогтоон боловсрол, эрүүл мэнд, эрчим хүчний салбарт бодлогын шинэчлэл хийх, нийгмийн хүлээлт үүсгэж буй багш, ажилчдын нийгмийн баталгааг хангах, цалинг нэмэгдүүлэх, ахмад настны тэтгэвэр, тэтгэмжийг тухайн жилийн инфляцтай уялдуулан нэмэгдүүлэхэд онцгой анхаарал хандуулан ажиллаж байгаа юм байна.

Мөн тэрээр МБҮА ТББ-ийн Ажлын албанаас сар бүр тогтмол гаргаж олон нийтэд танилцуулдаг судалгааны талаар мэдээлэл өгч, хөтөлбөрт хамрагдаж байгаа УИХ-ын гишүүдийн Ажлын албатай санал солилцож цаашид хамтран ажиллах талаар ярилцлаа.

Б.САРАНЧИМЭГ: **НҮБ-ААС МОНГОЛ УЛСЫН БАРИЛГА, ОРОН СУУЦНЫ ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД**

Барилга, дэд бүтэц, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн мэдээллийг байнга баяжуулж, цуврал судалгааг НҮБ-ын 80 жилийн ойд зориулан “НҮБ-аас барилга, орон сууцны чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр” сэдвээр бэлтгэн цахим ном хэлбэрээр болон видео контент бэлтгэн нийтэд хүргэлээ. Мөн удирдлагын өгсөн үүргийн дагуу хийсэн судалгаа бүрийг байгууллагын веб хуудсанд байршуулах, тогтмолжуулах, сар бүрийн цуврал видео контентоо гаргах чиглэлээр ОНХ менежертэй хамтран ажиллаж байна.



Үр дүн: Гишүүн байгууллагуудыг албан ёсны тоон мэдээллээр хангахад чухал ажил болсон.

БАРИЛГЫН НОРМ, НОРМАТИВИЙГ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГААР БОЛОВСРУУЛДАГ БОЛНО



Барилгын ерөнхий хууль, Хот байгуулалтын тухай хууль, Орон сууцны ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга,Үндэсний орон сууцжуулалтын тухай зэрэг барилгын салбарын багц хуулийн төслүүдийг боловсруулан, батлуулах Ажлын хэсэг дахин шинэчлэгдэж бүрэлдэхүүнд МБҮА ТББ орж идэвхтэй ажиллаж байгаа бөгөөд Барилгын ерөнхий хуулийн төсөлд өгсөн саналаас 6 нь тус хуульд орохоор тусгагдаад байгаа.

Тус Ажлын хэсгийн ээлжит хуралдаан 2025.10.14-ны өдөр Хот байгуулалт, орон сууцжуулалтын яаманд болсон бөгөөд хурлаар Барилгын ерөнхий хуулийн үзэл баримтлалын төслийн зарчмын саналууд дээр нэмэгдээд Магадлал, Улсын комисс, Захиалагчийн хяналт зэрэг төр дангаараа гүйцэтгэдэг үүргийг зөвлөх үйлчилгээгээр, норм нормативийг эрдэм шинжилгээний байгууллагаар боловсруулуулах нь мэргэжлийн өндөр түвшинд, шударга, хараат бус зарчмын дагуу, хуулийн болон зохицуулалтын шаардлагыг хангах нь үр дүнтэй гэдэг дээр санал нэгдлээ. Мөн төсөв, үнэ бүрдлийн талаарх асуудлыг дахин хэлэлцэхээр тогтлоо.

Мөн Барилгын ерөнхий хуулийн үзэл баримтлалын талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг ирэх 11-р сард багтаан хийж улмаар 12 сар болон ирэх оны эхний улиралд багтаан багцлан хаврын чуулганаар өргөн барихаар төлөвлөлөө.

3.ГИШҮҮНЧЛЭЛ УЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ХУРЭЭНД

МБУА
МОНГОЛЫН БАРИЛГЫН УНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Зөв зүгт Манлайлна

www.mnca.mn

МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН УЛЬТРАСОНИК ХХК НЬ ISO9001:2015 СТАНДАРТЫГ ҮЙЛЧИЛГЭЭНДЭЭ НЭВТРҮҮЛЛЭЭ




Ногоон Технологи • Герман Инженерчлэл • Амьдралын Чанарыг хүргэнэ уриатай МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн байгууллага Ультрасоник ХХК нь 2001 онд үүсгэн байгуулагдсан цагаас эхлэн баруун Европын тэр тусмаа ХБНГУ-ын хамгийн дэвшилтэт, орчин үеийн ногоон технологи, инженерингийн төгс шийдлүүдийг зах зээлд нэвтрүүлэн, хэмнэлт, үр ашгийг хүргэх замаар хэрэглэгчдийнхээ ая тухыг хангаж, амьдралын чанарыг дээшлүүлэхийн төлөө ажиллаж байгаа хамт олон билээ.
Үйлчилгээндээ ISO9001:2015 стандартыг нэвтрүүлж олон улсын бизнесийн загварчлалыг мөрдөж ажиллаж буй Ультрасоник ХХК-ийн хамт олон болоод Б.Чимэгцэцэг захиралд МБҮА ТББ-ын нийт Гишүүдийн өмнөөс халуун баяр хүргэе.

БАРИЛГЫН САЛБАРЫН ХАБЭА-ОСОЛ ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛАХАД ХЭРХЭН АНХААРАХ ВЭ?



МБҮА ТББ нь Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яам, Барилгын хөгжлийн төвтэй хамтран барилгын салбарын удирдах ажилтнуудад зориулан ХАБЭА-н хууль тогтоомж, эрсдэлийн удирдлага, зохион байгуулалт болон байгууллагын ХАБЭА -н чадварын мэдлэг олгож чадавхижуулах, болзошгүй осол эрсдэлээс хэрхэн сэргийлэх талаар БАРИЛГЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ХАБЭА СУРГАЛТ-ыг 2025.10.23-ны өдөр зохион байгуулж сургалтыг Монгол Улсын зөвлөх инженер, ХАБЭА-ийн сургагч багш Ч.Чинзориг хийлээ.



МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан: Барилга байгууламжийн бүтээн байгуулалтын ажил эрчимтэй өрнөж байгаатай холбогдуулан барилгын салбарт үйлдвэрлэлийн ослын тоо буурахгүй эрдэнэт хүний амь нас эндэх, хөдөлмөрийн чадвар алдах зэрэг асуудал олноор гарч байна. Улсын хэмжээнд барилгын салбарт сүүлийн 5 жилд 180 үйлдвэрлэлийн осол бүртгэгджээ. Ослын шалтгааныг авч үзвэл, нийт ослын 39,4 хувь нь өндрөөс унах, бүдрэх, хальтрах, 16,6 хувь нь эд зүйлд хавчуулагдах, 16,1 хувь нь унаж байгаа эд зүйлд цохиулах гэсэн хүчин зүйлээс хамаарч байна. Иймд бид цаашдын үйл ажиллагаандаа ХАБЭА-ийг сахин баримтлах, хэрэгжүүлэх нь нэн тулгамдсан асуудал байгааг онцолсон юм.
Харин Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны газрын дарга Д.Энхбаатар: МБҮА ТББ, Барилгын хөгжлийн төвтэй хамтран энэ удаагийн сургалтыг хамтран зохион байгуулж байна. ХАБЭА гэдэг маань хүний эрүүл, аюулгүй орчинд ажиллах, амьдрах нөхцлийг ханган ажиллах хамгийн эхний дүрэм бөгөөд барилгын салбарт ажиллаж байгаа олон зуун ажилчин, албан хаагчдын хувьд ХАБЭА-ийг сахин хэрэгжүүлж ажиллах томоохон салбарын нэг гэдгийг чухалчилж, цаашид л уламжлал болгон сургалтыг

явуулна гэдгээ уламжиллаа. Барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй ихэнхи аж ахуйн нэгж, байгууллага нь ХАБЭА-н хууль тогтоомж, стандарт, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлдэггүй, ХАБЭА-н ажилтан, алба,



хэлтсийг зохих орон тоогоор ажиллуулдаггүй, орон тооны тогтвортой ажилчид байхгүй, олон чиглэлээр түр зуурын туслан гүйцэтгэгч авч ажиллуулдаг, ХАБЭА-н урьдчилан арга хэмжээнд шаардлагатай хөрөнгө зардал гаргадаггүй, ХАБЭА-н менежментийн тогтолцоо нэвтрүүлдэггүй зэрэг нь энэ салбарт үйлдвэрлэлийн осол гарах, улмаар ажилтны амь нас, эрүүл мэнд хохирох үндсэн шалтгаан болж байгаа юм.

Иймд энэхүү сургалтаар барилгын салбарын ажлын онцлог, эрсдэлийн үнэлгээ, техник технологи, аюулгүй байдал нь ямар хууль, эрхзүйд нийцүүлсэн байх ёстой юм, барилгын салбарт хөдөлмөрийн аюулгүй байдлыг хэрхэн мөрдөж ажиллах вэ, ямар аюул эрсдэл учрах вэ, үүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ, ямар хууль эрхзүйг баримтлан ажиллах вэ гэдгийг салбарын удирдах ажилтнууд болоод ИТА нарт хүргэлээ.

Сургалтаар ХАБЭА-ийн олон улсын жишиг, стратеги төлөвлөлт, анхаарах талаар суралцагчид асууж өөрсдийн ажлын байр дээр гараад байгаа кейс, баримтыг хэрхэн шийдвэрлэх, юуг ажлын талбай дээрх осол гэж үзэх, хууль эрх зүйн хүрээнд ажилчдын аюулгүй байдлыг хэрхэн хангах, ажлын байр дээр осол эндэгдэл гаргахгүй байх тал дээр хэрхэн анхаарах зэргээр харилцан ярилцаж, мэргэжлийн багшаас зөвлөмж, зөвлөгөө авсан ач холбогдолтой арга хэмжээ боллоо.







ХАБЭА-ИЙН АРГА ХЭМЖЭЭ БОЛООД ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДЫН СПОРТ ӨДӨРЛӨГИЙН БАННЕР, ПОСТЕР, ӨРГӨМЖЛӨЛИЙН ЭХИЙГ БЭЛДЭЖ ТҮГЭЭВ.





МОНГОЛ УЛС , БНХАУ-ЫН НИНБО ХОТ - ЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН УУЛЗАЛТ БОЛЖ, 50 ГАРУЙ КОМПАНИ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БОЛОМЖИЙГ ЭРЭЛХИЙЛЭВ

Монгол Улс болоод БНХАУ-ын Жэжян мужийн Нинбо хотын бизнес эрхлэгчдийг холбосон уулзалт, бизнес форум 2025 оны 10-р сарын 14-ний өдөр МҮХАҮТ-ын Их танхимд амжилттай болж өндөрлөлөө. "Монгол Хятадын Худалдааг Дэмжих Холбоо" болон БНХАУ-ын Жэжян мужийн Нинбо хотын "Хилийн Чанад Дахь Бизнес Эрхлэгчдийн Худалдааны Танхим"-ын хамтран зохион байгуулсан энэхүү чухал арга хэмжээнд хоёр талын нийт 50 гаруй бизнесийн байгууллага оролцлоо.

Уулзалтад оролцогч талууд хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтын шинэ



боломжуудыг эрэлхийлэх зорилгоор мэдээлэл солилцлоо.

Нинбо хотоос барилга, интерьер дизайн, эрүүл мэндийн технологи, эмийн үйлдвэрлэл, электроник үйлдвэрлэл, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, хөнгөн үйлдвэрлэл, үнэт чулуун эдлэлийн үйлдвэрлэл худалдаа, урлагийн бүтээлийн чиглэлийн 20 гаруй компани, Монгол Улсаас 30 гаруй бизнесийн байгууллагууд оролцон үйл ажиллагаагаа танилцуулж, B2B уулзалт зохион байгуулагдлаа.

Мөн тус арга хэмжээний үеэр Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-ын Гадаад харилцааны менежер Ц.Нямдаваа "Монгол Улсын барилгын зах зээл, ерөнхий тойм" сэдвээр илтгэл тавьж, байгууллагынхаа танилцуулга болон Монголын барилгын салбарын боломжийн талаар мэдээлэл өгөв.

Хоёр орны бизнес эрхлэгчдийн хоорондын шууд харилцааг өргөжүүлсэн энэхүү уулзалт нь цаашид худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чухал алхам болно хэмээн зохион байгуулагчид үзэж байна.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

АЖЛЫН АЛБАНЫ БҮАТЗХ-ИЙН “НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ”-ИЙН ТОЙМ

БҮАТЗ-ийн хэлтэс нь “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан 1000 гаруй хуулийн этгээд, иргэдийг тухай бүр нь мэдээллээр ханган ажиллав.



БҮАТЗ-тэй холбоотой “Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд тавих нөхцөл, шаардлагын дагуу барилгын тусгай зөвшөөрлийг license.mn-ээр хүссэн **78**-н хуулийн этгээдийн хүсэлт, материалыг баталгаажуулж, ХББОСЯ-нд 2025.09.30-ны өдөр албан бичиг болон цахимаар илгээж ХББОССайдын 2025.10.20-ны өдрийн 229 дугаар тушаалаар баталгаажуулан ирүүлсэн.

ХББОССайдын 2025 оны 124 дүгээр тушаалын дагуу “Зөвшөөрлийн цахим систем”-д шилжих ажлыг зохион байгуулан 2025.09.05-ны өдрөөс эхлэн “LICENSE.MN”-ээр хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж эхэлсэн.

Тайлант хугацаанд license.mn-ээр хүсэлт гаргасан БУ:173, ЗТ:29, ӨБ:4 нийт **206**-н хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулан ажиллав.

Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор license.mn-ээр хүсэлт гаргасан **349** хуулийн этгээдийн хүсэлт хянагдаж, **1** удаагийн **БАТАЛГААЖУУЛАЛТ**-аар **78** хуулийн этгээдийн хүсэлтийг ХББОССайдын тушаалаар баталгаажуулсан. Дараагийн ээлжинд **206** хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулан ХББОСЯ-нд хүргүүлэхээр ажиллаж байна.



Үүнээс: №1 дүгээр баталгаажуулалтаар Барилга угсралт **57**, Зураг төсөл **18**, Өргөх байгууламж **3** хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулав.

№2 дугаар баталгаажуулалтаар Барилга угсралт **173**, Зураг төсөл **29**, Өргөх байгууламж **4** хуулийн этгээдийн хүсэлтийг баталгаажуулан ХББОСЯ-нд хүргүүлэхэд бэлтгэн ажиллаж байна.


Хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийг шалгаж 55 хуулийн этгээдийн материалыг шаардлага хангаагүйн улмаас буцаасан.

Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад тавих нөхцөл, шаардлагын дагуу тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсэн **78** хуулийн этгээдийн хүсэлтийн материалыг хянаж **342** инженер, техникийн ажилтнуудын бүртгэлд хяналт тависан бол **206** хуулийн этгээдийн хүсэлтийн материалыг хянаж **902** инженер, техникийн ажилтнуудын бүртгэлд хяналт тависан.


- БҮАТЗ-ийг эзэмшигч хуулийн этгээдийн мэдээллийг холбогдох хууль тогтоомж болон ХББОССайдын 1 удаагийн тушаалын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын opendata.burtgel.gov.mn-д БУ: 5284, ЗТ: 1047, ӨБ: 190 хуулийн этгээдийн нийт **6521** мэдээллийг нээлттэй байршуулах хүсэлтийг хүргүүлэв.

- БҮАТЗ-тэй хуулийн этгээдийн мэдээллийн санд “Холбогдох бичиг баримт хэсэг”-т БУ: 4728, ЗТ: 958, ӨБ: 168 нийт **5854** хуулийн этгээдийн мэдээллийг үүсгэн www.mcis.gov.mn-ын нээлттэй байршуулав.
- Цахим Хөгжил, Харилцаа Холбооны Яам (ЦХХХЯ)-ны тусгай зөвшөөрлийн цахим системд тайлант хугацаанд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын тушаалаар гарсан БУ: 57, ЗТ: 18, ӨБ: 3 нийт **78**-н хуулийн этгээдийн мэдээллийг хүргүүлсэн.
- ХББОС-ын Сайдын тушаалаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авч, гэрээ байгуулах тухай нийт **388** хуулийн этгээдэд масс мессежээр мэдээлэл хүргүүлэв.
- Зөвшөөрлийн нэгдсэн систем /https://license.mn//-д шилжсэнтэй холбоотой **CALL CENTER-ийн** бүтцийг өөрчилөн шинэ бүтэц зураглан шинээр алхамт нэмэв. Холбогдсон үйлчилгээ авах хэрэглэгчийн залгасан дугаарт **SMS-ээр хүссэн мэдээллийг нь явуулдаг** болгосон. Мөн **fb.com дээр chatplugin асааж chatbot ажиллагаанд оруулсан.** License.mn-ны гарын авлага дээр мэдээллийг засварлан сайжруулан байршуулсан.
- Tz.mnca.mn цахим хуудсын хөгжүүлэлтийг хийж Барилгын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг нэг дороос авах боломжтой цахим хуудсыг хөгжүүлэн цаашид холбогдох мэдээллийг төрөлжүүлэхээр ажиллаж байна.

БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ӨМНӨ НЬ АВЧ БАЙСАН ДАРААЛАЛ



БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ОДОО АВЧ БАЙГАА ДАРААЛАЛ



ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

УБ БОЛОН ДАРХАН-УУЛ АЙМАГТ ЯВАГДСАН "ХЯЛБАР ШИЙДЭЛ" АЯНЫ ДЭЭВРИЙН ДУЛААЛГАД ТӨСЛИЙН ДУЛААЛГЫН ЗӨВЛӨХҮҮДИЙГ АЖИЛЛУУЛАВ










"Хялбар шийдэл" аяны хүрээнд Улаанбаатар хотын 6 дүүргийн (СХД, СБД, БГД, ЧД, ХУД, БЗД) тодорхой болзол хангасан 100 айл өрхийн дээврийн дулаалгын ажлыг хэмжилтийн хамт УБ хотод барилгын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг, төслийн 5 дулаалгын зөвлөх нь багийн гишүүдийн хамт 2025 оны 10 дугаар сарын 2-6-нд хийж гүйцэтгэв.

“ХЯЛБАР ШИЙДЭЛ” АЯН-ДАРХАН:

“Дулаан шийдэл II” төсөл нь нийгмийн хариуцлагын хүрээнд, “Хялбар шийдэл” аяныг өрнүүлж, тодорхой болзол хангасан айл өрхүүдэд дээврийн дулаалгын урамшуулал олгодог. Аяны энэ жилийн онцлог нь тухайн айл өрхийн байшингийн дулаан алдагдлыг тодорхойлж, 10 см-ын дээврийн дулаалгыг төслийн санхүүжилтээр хийж өгч байгаа юм. Төслийн үйл ажиллагаа орон нутагт тэлж байгаатай холбогдуулан, энэ сарын 17-26-ны хооронд Дархан-Уул аймгийн Дархан сумын 7, 8, 15-р багийн, дээрх аяны болзол хангасан 40 айл өрхөд дээр дурдсан дээврийн дулаалгыг төслийн дулаалгын зөвлөх, бригадын ахлагчид болох Л.Түвшинжаргал, Х.Болортунгалаг, Ц.Батгэрэл, Н.Саранбаяр, Д.Төмөрхуяг нараар удирдуулсан 14 хүн хийж гүйцэтгэв. Тодруулбал, Дархан-Уул аймаг үйл ажиллагаагаа явуулдаг төсөлтэй хамтран ажилладаг дулаалгын зөвлөхүүд болон 2025.10.13-16-нд төслөөс зохион байгуулсан “Барилгын дулаалгын технологи ба хяналт” сургалтад хамрагдсан, цаашид төсөлтэй хамтран ажиллах сонирхлоо илэрхийлсэн барилгын салбарын бизнес эрхлэгчид гүйцэтгэгчээр ажилласан юм.

“БАРИЛГЫН ДУЛААЛГЫН МАТЕРИАЛУУДЫН ШИНЖ ЧАНАР, ОНЦЛОГ” СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА






“ХЯЛБАР ШИЙДЭЛ” АЯН-УБ ХОТ

МБҮА ТББ-ын “Дулаан шийдэл II” төслийн баг нь “Барилгын дулаалгын материалуудын шинж чанар, онцлог” сэдэвт сургалтыг Жэрэс ОУТББ-тай хамтран 2025 оны 10 дугаар сарын 3-нд зохион байгууллаа.
Төслийн 20 орчим дулаалгын зөвлөх оролцсон уг сургалтад хамтран ажилладаг нийлүүлэгч компаниудаас Монгол базальт ХК, Пирамид индастри ХХК, Росторг ХХК оролцож, өөрсдийн нийлүүлдэг барилгын дулаалгын материалуудынхаа талаар дэлгэрэнгүй танилцуулж, оролцогчдын сонирхсон асуултад хариулсан юм.

DULAALGA.MN ВЕБ СИСТЕМИЙН ХЭРЭГЛЭЭ, АШИГЛАЛТЫГ ШАЛГАВ





Төслийг хамтран хэрэгжүүлэгч Жэрэс ОУТББ нь тус байгууллагын захиалгаар "Дулаан шийдэл" вэб системийг шинэчилсэн Хан хөлгөн ХХК-тай хамтран 2025.10.10-нд "Дулаан шийдэл II төслийн dulaalga.mn вебсистемийн хэрэглээ, ашиглалт" сургалтыг зохион байгууллаа. Сургалтад төслийн 10 орчим дулаалгын зөвлөх оролцож, вэб суурьтай “Хувийн сууцны дулаан алдагдлыг илрүүлэх үнэлгээний маягт” болон “Дулаалгын ажлын гүйцэтгэлийн актууд”-ыг үйлдэж, системийн үйл ажиллагааг шалгав. Манай багаас системээр төслийн техникийн үнэлгээ болон дулаалгын ажлыг дулаалгын зөвлөхүүдэд хуваарилах дэд цэсүүдийн ажиллагааг шалгаж, төслийн нийт дулаалгын зөвлөхүүдээ төлөөлж, системийг сайжруулах шаардлагатай зарим саналаа дэвшүүлсэн юм.

ТОГТВОРТОЙ, НОГООН АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГИЙГ ТАНИУЛСАН “GREEN DAY” ӨДӨРЛӨГТ ОРОЛЦОЖ, ИРГЭДЭД МЭДЭЭЛЭЛ ӨГЛӨӨ






“Дулаан шийдэл2” төсөлтэй хамтран ажилладаг Хаан банкнаас 2025.10.11-нд, тогтвортой, ногоон амьдралын хэв маягийг таниулсан “GREEN DAY” өдөрлөгийг олон нийтэд зориулан зохион байгууллаа. Тус өдөрлөгт төслөө төлөөлөн, Монголын Ногоон Санхүүгийн Корпораци ТББ оролцсон бөгөөд иргэдэд барилгын дулаалга, эрчим хүч хэмнэлтийн ач холбогдлын талаар зөвлөгөө, мэдээлэл өглөө. Энэ нь эргээд төсөлтэй хамтран ажилладаг барилгын салбарын бизнес эрхлэгчдийн борлуулалтыг нэмэгдүүлэх нэг хөшүүрэг, арга хэмжээ болсон юм.

"НОГООН БАРИЛГЫН ҮНЭЛГЭЭ BESTGER АРГАЧЛАЛ, ҮНЭЛГЭЭНИЙ ТӨРӨЛ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ" ЗЭРЭГ СЭДВЭЭР МЭДЛЭГ МЭДЭЭЛЭЛ ОЛГОВ

2025.10.15-нд Ногоон Барилгын Хүрээлэн ТББ-иас зохион байгуулсан "Ногоон барилгын үнэлгээ BestGER аргачлал, үнэлгээний төрөл, шалгуур үзүүлэлт болон Ногоон барилгын BestGER гэрчилгээ олгох журам - Гэрчилгээжүүлэх процесс, оролцогч талууд" сургалтад хүсэлтээ илэрхийлсэн төслийн 14 дулаалгын зөвлөхийг хамруулав. Сургалтаар BestGer гэрчилгээний тухай, тэр дундаа урьдчилсан болон ногоон барилгын гэрчилгээний ялгааг танилцуулж, гэрчилгээжүүлэх үйл явц, гэрчилгээ олгох журмын талаар дэлгэрэнгүй тайлбарлалаа.



ДАРХАН-УУЛ АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛСАН “БАРИЛГЫН ДУЛААЛГЫН ТЕХНОЛОГИ БА ХЯНАЛТ” СУРГАЛТАД ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАЛАА

Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан шийдэл II” төслөөс Дархан-Уул аймгийн төрийн байгууллага, барилгын салбарын ААНБ, бизнес эрхлэгчид, коллеж зэрэг төлөөллийг хамруулсан “Барилгын дулаалгын технологи ба хяналт” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтыг төслийг хамтран хэрэгжүүлэгчдийн нэг ШУТИС-ийн дэргэдэх Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв удирдан явуулав. Манай МБҮА ТББ-ын Дулаан шийдэл II төслийн баг нь сургалтад дээр дурдсан талуудын оролцоог хангасан юм.

Мөн сургалтад идэвхтэй хамрагдсан Дарханы оролцогчдыг төслийн чадавхжуулах сургалтууддаа үе шаттай үргэлжлүүлэн хамруулан, тогтвортой байдлыг нь хангах арга хэмжээнүүддээ оролцуулах, барилгын эрчим хүч хэмнэлт, дулаалгын ажлуудад зуучилж, нэмэлт орлогоор хангах нөхцөлийг бүрдүүлэх боломжтой гэдгээ танилцууллаа.

Түүнчлэн сургалтдаа идэвхтэй хамрагдсан оролцогчдод төслөөс олгодог барилгын багажаар урамшуулав. Ийнхүү Дарханы оролцогч талууд төслийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, агаарын бохирдлыг бууруулах, хүлэмжийн хийн ялгарлыг багасгахад бодит хувь нэмрээ оруулах сонирхолтой байгаагаа бидэнд илэрхийлсэн юм.

Сургалтад хамрагдсан талууд:

- Дархан дахин төлөвлөлт ААТҮГ
- Дархан-Уул аймаг дахь Политехникийн коллеж
- Эрчим хүчний зохицуулах зөвлөл
- Хунт-Улз ХХК
- Алтай оргил ХХК
- Эко вүүл хаус ХХК
- Росторг ХХК
- Вишнфанд Монгол ББСБ
- Дархан-Уул аймаг дахь барилгын салбарын бизнес эрхлэгчид

ОРОЛЦОГЧ ТАЛУУД СПОРТООР НӨХӨРЛӨХИЙН САЦУУ ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГАА ТЭЛЛЭЭ







Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй "Дулаан шийдэл II" төслөөс УБ хотноо зохион байгуулсан “Спортын нөхөрсөг өдөрлөг” амжилттай болж өндөрлөв.

Өдөрлөгт “Дулаан шийдэл II” төсөлтэй хамтран ажилладаг УБ хотод үйл ажиллагаагаа явуулдаг барилгын салбарын бизнес эрхлэгчдээс 20 гаруй дулаалгын зөвлөх, МБҮА ТББ-ын гишүүн байгууллагуудаас Би Ай Би Дисковери ХХК, Эвэр туурай ХХК, Гурван бухат групп ХХК, Бодь Пропертийз ХХК-ийн төлөөллүүд болох 15 хүн, төслийг хамтран хэрэгжүүлэгчид болох Жэрэс ОУТББ, ШУТИС-ийн дэргэдэх Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв, Монголын Эмэгтэйчүүдийн















Сан, Монголын Ногоон Санхүүгийн Корпорацийн төлөөллүүд оролцлоо.

Оролцогчид дартс, боулинг, байт харваа, хийн буудлага гэсэн төрлөөр нөхөрсгөөр өрсөлдөхийн сацуу харилцаа, хамтын ажиллагаагаа тэлсэн үр дүнтэй байв. Тус өдөрлөгийг зохион байгуулсан МБҮА ТББ-ын “Дулаан шийдэл II” төслийн багаас тэмцээний төрөл тус бүрд тэргүүн байр эзэлсэн баг, тамирчдыг өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулсан юм. Шагналыг Жэрэс ОУТББ-ын Монгол дахь Суурин төлөөлөгч Завьер Рат гардуулав.

Боулингийн төрөлд, төслийн УБ хотын дулаалгын зөвлөх М.Анхмаа, Жэрэс ОУТББ-ын төлөөлөл М.Маргад, Бодь Пропертийз ХХК-ийн төлөөлөл Э.Лхагвамөрөн, Би Ай Би Дисковери ХХК-ийн төлөөлөл Д.Нямдолгор, Б.Сарантуяа нар тэргүүн байр эзэлсэн.

Дартсын төрөлд, төслийн УБ хотын дулаалгын зөвлөх Н.Дабааням, МБҮА ТББ-тай хамтран ажилладаг Сэлбэ хорин минутын хот корпорац ХХК-ийн төлөөлөл болох Ц.Бар, Б.Билгүүн нар шилдгээр шалгарсан.

Хийн буудлагын төрөлд, төслийн УБ хотын дулаалгын зөвлөх С.Батнасан тэргүүллээ.

Байт харвааны төрөлд, төслийн УБ хотын дулаалгын зөвлөх О.Эрдэнэхүүгийн багийн гишүүн Б.Төгөлдөр тэргүүн байранд оров.

АХА тэмцээнд, төслийн УБ хотын дулаалгын зөвлөх Р.Сарнай, Бодь Пропертийз ХХК-ийн төлөөлөл Э.Лхагвамөрөн нар ялагч боллоо.

Өдөрлөгийн азтанаар, төслийн УБ хотын дулаалгын зөвлөх Ц.Хөгжилмаа, Д.Нямгэрэл, Ш.Баярсайхан нар тодорсон.

ХАГАС ЖИЛИЙН ТОГТМОЛ ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ДУЛААЛГЫН ЗӨВЛӨХҮҮДИЙГ ШАГНАЖ УРАМШУУЛЛАА

“Дулаан шийдэл II” төсөлтэй хамтран ажилладаг УБ хотын барилгын салбарын бизнес эрхлэгчдээс 2024 оны 12 дугаар сараас 2025 оны 5-р сарыг дуустал хугацаанд төслийн техникийн үнэлгээ болон дулаалгын ажил хийж гүйцэтгэсэн 22 дулаалгын зөвлөхөөс “Хагас жилийн тогтмол



гүйцэтгэлтэй эхний 5 дулаалгын зөвлөх"-ийг шалгуур үзүүлэлтийн дагуу тодруулав. Ингээд дурдсан хугацаанд гүйцэтгэлээрээ шалгарсан дулаалгын зөвлөхүүд болох Д.Нямгэрэл, Ц.Цогт-Эрдэнэ, Ц.Пүрэв, Ц.Гаябазар, Ш.Баярсайхан нарыг шагнаж урамшуулав.

“ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БАГЦ” ОЛГОЛОО

Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй "Дулаан шийдэл II" төсөлтэй хамтран ажилладаг





бизнес эрхлэгчдийг барилгын ажлуудаа гүйцэтгэх явцад, барилгын талбай дээр ажиллаж байх үедээ өөрийн болон багийн гишүүдийнхээ аюулгүй байдлыг хангаж байхыг МБҮА ТББ-ын “Дулаан шийдэл II” төслийн багаас уриалж, энэ ч үүднээс “Хөдөлмөрийн аюулгүй байдлын жишиг багц” бэлтгэлээ. Энэхүү багцыг УБ болон Дархан-Уул аймаг дахь төсөлтэй хамтран ажилладаг барилгын салбарын бизнес эрхлэгчид, төслийн дулаалгын зөвлөхүүдэд олгохоор төлөвлөсөн. Энэ дагуу эхний 21 багцыг 2025 оны 10 дугаар сарын 25-нд болсон “Спортын нөхөрсөг өдөрлөг”-т оролцсон дулаалгын зөвлөхүүдэд олголоо.



“ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСЛИЙН БАГИЙН 2025.10-Р САРЫН ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОЙМ

Д/д	Үйл ажиллагаа	Тоон үзүүлэлт
1.	Барилгын салбарын БЖДБЭ-дэд зуучилсан техникийн үнэлгээний захиалга	22
2.	Техникийн үнэлгээний захиалгыг хуваарилсан барилгын салбарын БЖДБЭ-ийн тоо	11
3.	Барилгын салбарын БЖДБЭ-ийн хийж гүйцэтгэсэн техникийн үнэлгээний тоо	15
4.	Барилгын салбарын БЖДБЭ-дэд зориулан зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	8
5.	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээнд оролцсон барилгын салбарын БЖДБЭ-ийн тоо	111
6.	Арга зүйн зөвлөмжийг өгсөн барилгын салбарын БЖДБЭ-ийн тоо	35
7.	Санал, хүсэлт, гомдлыг нь шийдвэрлэсэн айл өрхийн тоо	10



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХҮРЭЭНД:







МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Монгол Улс, Улаанбаатар 15141,
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж,
МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот

7011 1515

info@mnca.mn

www.mnca.mn